

ДАРХАН ХОТЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМЫН
“ДАРХАНЫ ДАХИН СЭРГЭЛТ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Дархан хот

2020-05-25

Ардчилсан Намын Хорооны
...-р тогтоолын хавсралт

**2020 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**


ДАРХАНЫ АРДЧИЛСАН НАМ 2020-2024 оны ИТХ-ын сонгуульд Айл бүрийн амьдралын чанарыг сайжруулах, Шударга, хүртээмжтэй эдийн засгийг хөгжүүлэх “ДАРХАНЫ ДАХИН СЭРГЭЛТ” мөрийн хөтөлбөрөө сонгогч Та бүхэндээ толилуульж байна.

Дархан хотын дахин сэргэлтээр дараагийн шинэ жарныг эхлүүлэхийн тулд нутгийн удирдлагын хандлагыг өөрчлөх хөрөнгө оруулалт таатай орчинг бүрдүүлэх бүтээн байгуулалтын ажлыг оновчтой бүтээмжтэй болгох замаар иргэн бүрийг ажлын байртай, өрх бүрийг аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, нийтээрээ эрх тэгш хариуцлагатай, хүртээмжтэй, болгож төрийн албаны шинэ соёлыг төлөвшүүлэх нь бидний ЭРХЭМ ЗОРИЛГО юм.

Өнөөгийн нөхцөл байдал
2000 оноос хойш Дархан хотод тасралтгүй 20 жил МАН засагласан боловч иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулж чадаагүй нь бодит байдал болоод байна. Хот төлөвлөлт замбараагүй болсноос утаанд умбаж, өмхий үнэрт автаж хогондоо дарагдан, гэр хороолол нь төөрдөг байшин мэт эмх замбараагүй, хөрсний эвдрэл бохирдолд өртсөн “хоцрогдсон том сум” болоод байна. Бороо ороход гудамж талбай нь ус шаварт автдаг, байшингуудын дээврүүд хооронд эмх замбараагүй кабель сүлжилдсэн, газар олголт замбараагүй. Мэргэжлийн хяналт оновчгүйгээс хоцрогдсон технологи бүхий үйлдвэрүүд баригдаж байгаа нь ирээдүйд агаарын бохирдлын шинэ асуудал бий болгохыг олж харж чадахгүй байна

Дарханы дахин сэргэлтэнд зориулсан өөрчлөн байгуулалтын хууль эрх зүйн үндэс:

- Монгол улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт 2020 оны 05-р сарын 25-ны өдрөөс хэрэгжихтэй холбоотойгоор Дархан-Уул аймгийн статусыг өөрчилж Дархан хот болох хууль эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэхтэй холбоотой шинээр өөрчлөх батлагдах хууль журам дүрэмд иргэдийн санал авах, УИХ-д иргэдийн саналыг өргөн барих ажлыг зохион байгуулна,
- Засаг захиргааны нэгж, төрийн байгуудлагуудын бүтэц зохион байгуулалт, төрийн албаны залгамж чанар, уялдааг хангах замаар зохион байгуулна.
- Дархан хот болж байгаатай холбоотой хилийн цэсийг иргэдийн хүслээр шинэчлэх ажлыг зохион байгуулна.




Монгол улсын Үндсэн хуулийн 57-р зүйлийн 2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

- Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.
- /Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12 цагаас эхлэн дагаж мөрдөнө./
- 3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.
- 3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.
- /Энэ хэсгийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан бөгөөд 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12 цагаас эхлэн дагаж мөрдөнө./

ҮЙЛДВЭРЛЭГЧ ДАРХАН

Улаанбаатар, Эрдэнэт, Эрхүү хотууд болон газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүс нутгийн төвд орших газар нутгийн давуу талыг ашиглан, Дархан хотод барилга, төмөрлөгийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, газар тариалан, мал аж ахуйн салбарт түшиглэсэн экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төв болгож, импортоор авдаг жимс жимсгэнэ, хүнсний ногоо болон зарим төрлийн хүлэмжийн, нарийн ногоог дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтын хүрээнд.

- Арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэрийг дэмжиж хамтран ажиллана.
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр болон шинээр баригдсан төмөрлөгийн жижиг үйлдвэрүүдийн технологийг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлэх замаар хамтран төсөл хэрэгжүүлж ган хийц үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэр бий болгоно.
- Дархан хотын хүнсний ногоо тариалагчдыг хүнс үйлдвэрлэгч үндэсний болоод орон нутгийн томоохон аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж тэдний ханган нийлүүлэгч болоход дэмжлэг үзүүлнэ
- Дотоодын нөөц бололцоонд түшиглэн луувангийн шүүс, сармис нөөшлөх бага, дунд оврын үйлдвэрийг байгуулж, Дарханыг төлөөлөх дэлхийн брэнд бүтээгдэхүүн болгоно.
- Дарханы хүнсний ногоо тариалагч иргэдэд Дархан, Улаанбаатар хотуудад өөрсдийн бүтээгдэхүүнийг төвлөрсөн болон хэсэгчилсэн худалдааны цэгүүдээр дамжуулан борлуулах боломжуудыг бүрдүүлэхэд хувь хэвшлийн ААН-үүдтэй хамтран ажиллана.



АЖИЛ ХЭРЭГЧ ДАРХАН

- Арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэрийн түүхий эдийг ханган нийлүүлэх ажлыг орон нутаг болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулах замаар ажлын байр нэмэгдүүлнэ.
- Аж үйлдвэрлэл 4.0, технологийн хувьсгал, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжлэх ухааны эрин үед өөрчлөгдөн буй хөдөлмөрийн зах зээл, шинэ төрлийн ажлын байрны шаардлагыг хангах хөрвөх чадвар, өндөр мэдлэг бүхий мэргэжилтэн, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, сургах бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж төр хувийн хэвшлийн хамтын оролцоотой Дижитал Дархан хотыг бүтээхэд Орон нутгийн удирдлагын зүгээс бодлогын дэмжлэг үзүүлнэ
- Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.
- Хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэр (цагийн ажил, аутсорсинг, сүлжээний борлуулалт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ г.м.)-ийг бодлогоор дэмжинэ.
- Гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх экосистем (санхүүжилт, сургалт, мэдээлэл, г.м.)-ийг бүрдүүлэх бодлого баримтлана.
- Орон нутагтаа гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх бодлогыг тууштай баримтлах замаар ажлын байрыг тасралтгүй нэмэгдүүлнэ.

ЭРДМИЙН ДАРХАН

- Мэргэжлийн боловсрол эзэмшсэн, МСҮТ-үүдэд суралцаж буй оюутнууд болон мэргэжлийн боловсрол эзэмших хүсэлтэй 100 залуучуудыг өндөр хөгжилтэй улс орнуудад дадлагажуулж, мэдлэг, ур чадварыг нь сайжруулна.
- Боловсролын салбарт ажиллаж буй багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор “Багшийн сургалт хөгжлийн төв”-ийг барьж ашиглалтанд оруулах ажлыг шийдвэрлэнэ.
- Сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муу, хүн ам шигүү суурьшсан, алслагдсан болон шинэ суурьшлийн бүсүүдэд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг шинээр байгуулах ба жил бүр нэгээс доошгүй цэцэрлэг, сургууль барих ажлыг шийдвэрлэнэ.
- Дархан хотод үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн их дээд, мэргэжлийн сургуулиудыг түшиглэн “Мэдээлэл, технологийн төв” бүхий “Оюутны хотхон”-ийг бий болгох ажлыг эхлүүлнэ.
- Сургууль, цэцэрлэгийн орчинд хүүхэд аюулгүй, чөлөөтэй зорчих боломжийг бүрдүүлэх зорилгоор “Сургууль, цэцэрлэгт хүрэх хүүхдийн зам” төслийг хэрэгжүүлэн, хүүхдэд тохиолдох аливаа эрсдлийг арилгана.
- Хичээлийн гадуурхи боловсрол олгох сургалтын нэмэлт хөтөлбөрүүдийг (“Номтой нөхөрлөө”, “Мэргэжлээ зөв сонгоё”, “Сайн хүн больё” гм), аймгийн боловсролын

байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, дугуйлан, секц хичээллүүлэх, анги кабинетуудийг шинэчлэн тоноглох, компьютер, нарийн мэргэжлийн хичээлийн лаборатори байгуулах ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийнэ

- Хүүхэд залуучуудад Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Хүүхэд залуучууд өв уламжлалаа дээдлэх “Мэргэн дэмч” төсөл хэрэгжүүлнэ.


ХҮСЛИЙН ДАРХАН

Хүн бүрийн зорин ирдэг, зочлон тухладаг, бизнесээ цэцэглүүлдэг, амьдралыг дэмжих хөгжлийн татах хүчтэй Хүслийн хотын үндэс суурийг тавина.

“Дархан-Залуусын хот” хэмээх сайхан түүхийн үргэлжлэл болгон, шинэ залуу гэр бүлүүд, түүнчлэн байр шаардлагатай боловч тусдаа гарч чадахгүй байгаа гэр бүлүүдэд зориулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан “Түрээсийн орон сууцны хөтөлбөр”-ийг дэмжин хэрэгжүүлнэ. Түрээсийн орон сууцны хөтөлбөр нь түрээслэх явцдаа байрны төлбөрөө урт хугацаанд төлж байраа өөрийн эзэмшилд шилжүүлэн авах боломжийг иргэдэд олгох ба уг хөтөлбөрийг Засаг даргын мөрийн хөтөлбөрт оруулан, биелэлтийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллана.

Аятай тухтай, амгалан тайван амьдрах орчин:

- Дархан хотын гэр хорооллуудыг дахин төлөвлөлтөнд хамруулж, оршин суугч иргэдийн хүсэлтээр барилгажуулах, эсвэл амины орон сууц барих ажлыг бодлогоор дэмжинэ.
- Шинээр баригдах хороолол, хотхонууд, гэр хорооллын дахин төлөвлөлт болон зуслангийн бүс байгуулахад шаардагдах цахилгаан, дулаан, цэвэр усны шугамууд, авто зам зэрэг дэд бүтцүүдийг шат дараалалтайгаар шийдвэрлэнэ.
- Дархан хотын иргэдийг, баригдсан орон сууц худалдан авах болон шинээр амины орон сууц барихад зориулан ипотекийн зээлд хамруулах боломжийг бүрдүүлнэ.
- Иргэдийн цэвэр агаарт тав тухтай амьдрах боломжийг бүрдүүлэх зорилгоор зуслангийн бүсийг байгуулж, нээлттэй, ил тод, чирэгдэлгүй байдлаар иргэд зуслангийн газартай болох нөхцөл бололцоог бүрдүүлнэ.
- Шарын гол-Дарханы хооронд зам барих ажлыг дуусгаж, Зулзага, Салхитын чиглэлд хатуу хучилттай зам барих ажлыг Улсын төсвийн ХО-д тусгуулан гүйцэтгүүлнэ.
- Ундны усны хомсдолтой багуудад шинээр гүний худаг гаргуулах болон усны шугам татах ажлуудыг зохион байгуулна.
- Орон сууцнуудын ашиглалтыг сайжруулах, оршин суугчдын амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэх ажлыг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дэмжин ажиллана
- Дарханчуудад зориулсан зуслангийн бүсийг Зулзагын гол, Хараа голын хөндийд байгуулах ажлыг хийнэ.




- Хараа голын эрэг дагуу иргэдийн соёл амралтанд зориулсан цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
- Дархан хотын газар доорхи инженерийн байгууламжийн ашиглалтыг сайжруулж, Хонгилын систем нэвтрүүлэх судалгааны ажлыг эхлүүлнэ.

Иргэддээ ээлтэй хот:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүд болон ахмад настнуудыг сэргээн засах эмчилгээ, сувилалын үйлчилгээнд бүрэн хамруулах нөхцөл бололцоог сайжруулж тэдний зорчих дэд бүтцийг байгуулах ажлыг улсын төсвийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд шийдвэрлэх бодлого баримтлана.
- Дархан хотод хавдрын эсрэг оношлогоо, эмчилгээний төвтэй болно. Дархан хотын эрүүл мэндийн байгууллагуудын материал-техникийн баазыг бэхжүүлнэ.
- Олон улсын жишигт нийцсэн хөл бөмбөгийн талбайтай болох ажлыг хийнэ.
- Дархан хотын төв зам дагуу зориулалтын дугуйн зам байгуулах ажлыг санаачлан, ард иргэдийн эрүүл, зөв, хөдөлгөөнтэй амьдралыг дэмжих орчныг бий болгоно.
- Дархан хотын хүн ам цуглардаг нийтийн эзэмшлийн зам талбай, амралт, зугаалгын цэгүүдэд утасгүй интернетийн сүлжээ, нийтийн бие засах газруудыг шинээр бий болгоно.
- Хүүхдийн тоглоомын талбай дутагдалтай гэр хорооллуудад хүүхдийн тоглоомын талбай 10-г байгуулж, хүүхэд багачуудыг аюулгүй орчинд тоглож наадах боломжоор хангана.
- Баг бүрт нэгээс доошгүй байршилд өндөр настнууд, бага насны хүүхэдтэй эхчүүдэд зориулсан дуу чимээнээс хол, ногоон орчин бүхий жишиг нарлах талбай, сүүдрэвч байгуулах ажлыг зохион байгуулна.
- Дархан хотын төвийн болон захын хорооллуудын гудамж талбайн гэрэлтүүлгийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- Ард иргэдийн аюулгүй тайван байдлыг хангахад хууль хяналтын байгууллага – ард иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх үүднээс олон нийтийн сайн дурын эргүүлийн тогтолцоог нэвтрүүлж, камерын хяналтын системийн хамрах хүрээг нэмэгдүүлнэ.
- Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг сэргээж батласан тохиолдолд хүүхэд харах үйлчилгээг Дархан хотдоо бий болгох ажлыг хэрэгжүүлнэ

Хонгор сум



- Салхит-Хонгорын хооронд авто зам барих ажлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ.
- Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг бодлогоор дэмжинэ.
- Хонгор сумын төвөөр дайран өнгөрдөг Олон улсын зэрэглэлийн замын дагуу 2 талаар 500 метр үргэлжилсэн зогсоол хийж худалдааны гудамжтай болгоно.

Орхон сум

- Иргэдийг гадаадын хөрөнгө оруулагчидтай холбох, гадны төсөл хөтөлбөрт хамруулах замаар ногооны Агуулах, хүлэмж, зoorь шинээр барих ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- Орхон суманд Авто зам, Төв замын дагуу худалдааны гудамжтай болгоно.
- “Орхон бренд”-ийг бий болгоход ард иргэд, ААН-үүдийн үйл ажиллагааг чиглүүлнэ.

Шарын гол сум

- Дархан хот, Шарын гол сумыг хатуу хучилттай замаар холбох ажлыг эрчимжүүлж улсын төсвөөс санхүүжүүлэх асуудлыг дэмжиж шийдвэрлүүлнэ.
- Бичил уурхайчид орон нутагтаа ажил эрхлэх, бичил уурхайчдын үйл ажиллагаа, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- Ундны усны хомсдолын асуудлыг судлаж шалтгааныг тогтоосноор гадаадын тусламж төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.
- Орон сууцны дулаан хангамжийг сайжруулах ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.

Дарханчууд та бид хамтдаа ирэх 4 жилийг “Дарханы дахин сэргэлтийн он жилүүд” хэмээн Дархан хотын түүхэнд том үсгээр тэмдэглэгдэн үлдэх дуурсгалт цаг үе болгохын төлөө хамтдаа зүтгэцгээе хэмээн толилуулав.

